



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/86

Онги

Бруцеллёзын дархлаажуулалтыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тхай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8 дахь хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/179 дугаар тушаал, Дундговь аймгийн Засаг даргын А/457 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 2023 оны 08 дугаар сарын 14-ны өдрөөс эхлэн 09 дүгээр сарын 14-ны өдрийг хүртэлх хугацаанд багтаан зохион байгуулсугай.
2. Малчид, мал бүхий иргэдэд зарыг хүргэж графикт хугацаанд зөвхөн охин төлийг (хурга, ишиг, тугал) бүрэн хамруулахыг багийн Засаг дарга нар, Онги Таван-Эрдэнэ мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч (Б.Цэнгэлмаа) нарт үүрэг болгосугай.
3. Дархлаажуулалтын ажлыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр ханган, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (Ц.Саранчимэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЛУВСАНРАГВА